



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 260

Улаанбаатар хот

“Бодь даатгал” ХХК-д хувь нийлүүлсэн хөрөнгийн
хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулахыг
зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 355 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Бодь даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хувь нийлүүлэгч Л.Болд нь 400,000,400.0 /дөрвөн зуун сая дөрвөн зуу/ төгрөгийн мөнгөн хөрөнгөөр, Л.Болдхуяг нь 600 /зургаан зуу/ төгрөгийн мөнгөн хөрөнгөөр тус тус нэмэгдүүлж, нийт 3,900,544,000.0 /гурван тэрбум есөн зуун сая таван зуун тавин дөрвөн мянга/ төгрөгт хүргэх, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд орсон өөрчлөлтийг дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

№	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	
1.	Л.Болд	1,717,662,600.00	400,000,400.00	2,117,663,000.00	54.29%
2.	Л.Болдхуяг	1,782,880,400.00	600.00	1,782,881,000.00	45.71%
	Дүн	3,500,543,000.00	400,001,000.00	3,900,544,000.00	100%

2. Дүрмийн сангийн хэмжээ, бүтцэд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, хувийг Хороонд ирүүлэхийг “Бодь даатгал” ХХК /Б.Хангай /-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Т.Жамбаажамц/-т тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000847